***Д.Цэцэндалай** - Хууль сахиулахын удирдлагын акаде.мийн*
*821 дүгээр дамжааны суралцагч, онцгой байдлын дэд хурандаа*

# ГАЛ УНТРААХ УДИРДЛАГАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ.

***Хураангуй.*** Энэхүү *нийтлэлээр байгууллагын галын дохиололын системнйг мэргэшсэн байгуулагатай холбож байгууллагуудын мэдээллийн сантай болсноор болзошгуй объектын гал түймрийн үед хугацаа алдаж мэдээлэх асуудлыг шийдвэрлэх болон объектын талаархи мэдээлэлийг цахимаар хүлээн авч гал унтраах шуурхай удирдлага зохицуулалтыг эрсдлийн үнэлгээ, судалгааны үндсзн дээр оновчтой, шуурхай, төлөвлөлтийн дагуу зохион байгуулах асуудлыг хөндөж тавихыг зорилоо.*

***Тулхуур үг.*** *Обьектын гал түймэр, гал түймрийн шуурхай удирдлага, галын дохиололын систем, гал унтраах шуурхай төлөвлөлт.*

Гамшгийн эрсдэлийн менежментийн бодлого, үйл ажиллагаа нь гамшгийн эрсдэлийг үнэлэх, эмзэг байдал, чадавх, хүн ам, эд хөрөнгийн өртөх байдал, аюулын шинж чанар болон хүрээлэн буй орчны хүрээнд нөлөөлөх цар хүрээг тодорхойлон гамшгийн өмнө эрсдэлийн үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн бэлэн байдлыг хангах, хор уршгийг үр дүнтэй арилгахад чиглэгдэн хоорондоо маш нарийн уялдаа холбоо бүхий цогц арга хэмжээ юм.

Дэлхий дахинд цар хүрээ ихтэй, удаан үргэлжлэх хугацаатай, олон хүнийг хамарсан гамшиг тохиолдож байгааг нэн тэргүүний хэмжээнд авч үзэх болсон байна. Манай орны хувьд обьектын гал түймэр нь цар хүрээ, үргэлжлэх хугацаа бага ч нийт тохиолдож буй гамшиг ослын 80-90 орчим хувь, хохиролын 50 гаруй хувийг эзэлж давтамж болон хохирол их, хүн ам ихээр суурьших барилга байгууламжид үүсэн бий болж байгаа нь өнөөдөр гамшгаас хамгаалах менежмент болон гал түймрийн аюулын эрсдлийг бууруулах менежментийг зөв төлөвлөн зохион байгуулах зүй ёсны шаардлага урган гарч байна.

Дэлхий дээр дундажаар 5 тэрбум орчим гал түймэр гарч байгаа гэсэн тоо байдгаас үзвэл хоногт 13,6 сая, цагт 570.7 мянга, минутанд 9510, секундэд 159 том жижиг гал түймэр хаа нэгтээ гарч байна.

Манай оронд сүүлийн жилүүдэд гал түймрийн хэрэг зөрчил эрс өсч улс орны үндэсний болон эдийн засгийн хямралын байдал, иргэдийн амьдрал, аж ахуйн нэгж байгууллагын хэвийн үйл ажиллагаанд бодит бэрхшээл учруулж байна.

Олон жилийн дундажаас үзэхэд манай улсын хэмжээнд гарч буй гамшгийн 90 хувь, хохиролын 70-80 хувийг обьектын гал түймэр эзэлж байна. Монгол улсын хэмжээнд нийт 4381 удаа аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 230 хүн амь насаа алдаж, 61 хүн гэмтэж бэртэн 1,0 сая толгой мал, амьтан хорогдож, 43,1 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан. Эдгээрийн хор уршгийг арилгахад Онцгой байдлын албаны албан хаагчид болон орон нутгийн иргэд нийт 27454 хүн, 5057 автомашин ажиллаж, 1315 хүний амь нас, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 23,6 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах ажилд онцгой байдал болон орон нутгаас 1,4 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад улсын хэмжээнд аюулт үзэгдэл, осолд өртөж нас барсан хүний тоо 32-оор нэмэгдэж, гэмтэж бэртсэн хүний тоо 24-өөр буурсан байна.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Аврах, гал унтраах 49 анги 2016 онд гал түймрийн 3848 дуудлага хүлээн авч гал түймэр унтраах, авран хамгаалах ажлыг гүйцэтгэсэн байна.

Энэхүү судалгаанаас харахад гарч буй гал түймрийг 30 минутаас дээш хугацаагаар ажиллаж унтраасан 707 гал түймэр нь хугацаа алдаж гал гарсан тухай мэдээллийг дамжуулсан болон обьектын талаарх мэдээлэл, судалгаа байхгүйн улмаас гал түймрийг унтраахад хүндрэл гарч байдаг байна гэж үзэж болно.

Улаанбаатар хотод болон орон нутгийн хэмжээнд 2015 онд шинээр баригдах барилга байгууламжийн 1184 зураг төсөлд хяналт хийж баталгаажуулан, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээж авах улсын комиссын бүрэлдэхүүнд 1135 удаа орж ажиллав[1].

Дээрх мэдээнээс харвал жилд 1135 барилга байгууламж ашиглалтад орж байгаа нь хотжилт хэр хурдацтай явагдаж байгаа тод жишээ юм.

Галын аюулгүй байдлын тухай хууль, галын аюулгүйн норм дүрмийн заалтын дагуу сүүлийн үеийн барилга байгууламжуудад галын дохиололын системийг заавал хийсэн байхыг шаардах болсон нь гарсан гал түймрийг цаг алдалгүй мэдээлэх боломж бүрдэж байна.

1960-1980 оны үед баригдсан төрийн болон захиргааны (оффисын) барилга байгууламжууд нь галын дохиололын системийг төлөвлөөгүй барьсан байдаг байна.

[1] ОБЕГ-ын 2015 оны жилиийн эцсийн тайлан.

1970- аад оноос Монгол улсад аж үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж Зөвлөлт холбоот улс болон гадаад улсын дэмжлэгтэйгээр Дулааны цахилгаан станц, Гутлын үйлдвэр. Нэхмэлийн үйлдвэр, Мод боловсруулах үйлдвэр, Чихэр боовны үйлдвэрүүд баригдахын зэрэгцээ ард иргэдийн соёлын довтолгоо өрнөж Дуурийн театр, Хүүхэд залуучуудын ордон, Монголын үйлдвэрчний соёлын төв ордон зэрэг олон нийтийн барилга байгууламжууд ар араасаа баригдан Улаанбаатар хот өргөн тэлж барилгажилт болон үйлдвэржилт ид өрнөх болсон.

Энэ үед дээрхи барилга байгууламжуудад Зөвлөлт холбоот улсын болон Чех улсын мэргэжилтэн инженерүүдийн зураг төслөөр галын аюулаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, зарлан мэдээлэх, унтраах төрлийн галын дохиололын системийг нэвтрүүлэн ашиглаж ирсэн байна.

Энэ үед барилгын норм дүрэм стандарт гэх зүйл байхгүй байсан бөгөөд Зөвлөлт холбоот улсад мөрдөгдөж байсан стандарт норм дүрмийг удирдлага болгон баримтлан ажиллаж байсан байна.

Дээрхээс дүгнэж үзэхэд обьектын гал түймрийг унтраахад тулгамдаж буй асуудлуудыг авч үзвэл.

1. Гал гарсан тухай мэдээлэх дохиололын систем байхгүйн улмаас хугацаа алдаж мэргэжлийн байгууллагад гал гарсан дуудлагыг өгдөг.
2. Гал гарсан обьектын талаархи мэдээ мэдээлэл, судалгаа байдаггүй
3. Болзошгүй гал түймэр гарсан үед гал унтраах шуурхай төлөвлөгөө байхгүй.
4. Гал гарсан үед авах арга хэмжээ. эрсдлийн үнэлгээ хийгээгүй
5. Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч обьектын талаархи мэдээ, мэдээлэл байхгүй улмаас удирдлагын шуурхай шийдвэр гаргаж чаддаггүй зэрэг асуудлууд тулгамдаж байдаг байна.

Шийдвэрлэх асуудлыг хэрхэн тодорхойлсноос бодлогын үйл явцын дараагийн бүх үе шат, үр дүн үлэмж хэмжээгээр шалтгаална.

Хүмүүсийн хангагдаагүй хэрэгцээ, хэрэгжээгүй шаардлага, үнэт зүйл, нөгөөтэйгүүр тэдгээрийг төрийн бодлогоор шийдэх боломжийг бодлогын асуудал гэнэ. Галын аюулгүй байдлын тухай хууль болон галын стандарт норм дүрмээр аливаа барилга байгууламжийг галын дохиололын системээр тоноглогдсон байхыг шаардаж, улмаар барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авч байгаа ч уг тоног төхөөрөмжийг мэргэжлийн байгууллагатай хэрхэн холбох, хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг өнөөдөр төрийн бодлогоор зохицуулах шаардлагатай.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд цогц байдлаар зохион байгуулах зорилгоор Монгол Улсын Мянганы хөгжлийн

зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан 2011 онд 'Тамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого", ‘Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Монгол Улсын Их хурлаар батлан гаргаж, Засгийн газраас ‘Тамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг 2011-2020 он хүртэл хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Энэхүү бодлогын хүрээнд гамшгаас хамгаалах үндэсний чадавхыг бэхжүүлэх, гамшгийн эрсдлийг бууруулах асуудлыг Монгол Улсын дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөлттэй уялдуулах, гамшгаас хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, гамшгаас хамгаалах, эрсдлийг бууруулах үйл ажиллагааг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэ шатанд гаргах, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагыг дэлхийн бусад улс орон, шинжлэх ухаан, технологийн хөгжил дэвшилд ойртуулан орчин үеийн мэргэжлийн байгууллага болгон хөгжүүлэх асуудлыг стратеги, төлөвлөлттэйгээр хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй болох юм хэмээн тодорхойлсон байна.

Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 112 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөө’-нд Гамшгаас хамгаалах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож, шинжлэх ухаан, шинэ мэдлэг. дэвшилтэт технологид суурилсан, олон нийтэд түшиглэсэн гамшгийн менежментийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах үндэсний чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдлийг бууруулах, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагыг олон улсын жишигт хүрсэн мэргэжлийн байгууллага болгон хөгжүүлж, хүн ам, хүрээлэн буй орчныг гамшиг ослоос хамгаалахад Онцгой байдлын ерөнхий газрын дунд хугацааны стратеги зорилго оршино хэмээгээд тэргүүлэх зорилтын 3 дугаарт Гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, шинэ мэдлэг, дэвшилтэт техник технологи, инновацийг нэвтрүүлэх хэмээн тусгалаа олсон байгааг хэрэгжүүлэх цаг ирсэн байна.

Зах зээл хөгжсөн болон хөгжиж буй орнуудад гал түймэртэй тэмцэх ажлыг боловсронгуй болгох талаар олон төрлийн ажил хийж байгаагийн нэг нийтлэг хэлбэр нь төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, комнани, иргэдийн галын аюулгүй байдлыг автоматжуулалтын системээр хангах, болзошгүй гал түймрийн үед дохиололын системийг ашиглан богино хугацаанд мэдээллийг дамжуулах, гал түймрийг унтраах болон төрөл бүрийн аврах үйл ажиллагааг зохион

байгуулах төлөвлөгөө болон бусад шаардлагатай мэдээ мэдээллийг тусгасан төлөвлөлт юм.

Өнөөдөр манай орны хувьд Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох. улмаар дэлхийн бусад улсуудын нийтлэг жишигт хүргэх. түүний удирдлага, зохион байгуулалтад шинэ техник технологийг нэвтрүүлэх явдал нь бодит амьдралаас урган гарч байна.

Галын аюул бол хохирол өндөртэй, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зайлшгүй авах шаардлагатай ноцтой эрсдэл юм. Энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирол багатай даван туулахад зориулагдсан олон арга зам байдгийн нэг нь барилга байшин, объектыг галын аюулаас хамгаалах, гал гарах анхны шинж тэмдгүүдийг илрүүлэн мэдээлэх автомат систем буюу галын дохиоллын систем юм.

Дээрхи тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд дараахи саналыг дэвшүүлж байна.

1. Аливаа барилга байгууламжыг галын дохиололын системээр бүрэн тоноглож мэргэжлийн багууллагуудтай буюу хамгийн ойр байрлах гал унтраах ангитай хамтран ажиллах гэрээ төлөвлөгөөний дагуу холбож автоматжуулах.

2. Хамтран ажиллах гэрээ төлөвлөгөөний дагуу тухайн аж ахуйн нэгж байгууллага нь обьектын талаарх мэдээ мэдээлэл, болзошгүй гал түймрийн үед шуурхай унтраах төлөвлөгөөг боловсруулан жил тутам тодотгол хийж байх

3. Дээрхи төлөвлөгөөг цахимжуулан байршуулах

4. Гал гарсан тухай дуудлага галын дохиололын системээр харьяа гал унтраах ангид богино хугацаанд мэдээлэхэд гал гарсан обьектын танилцуулга болон барилгын зураг, гарсан галыг унтраах арга тактик, Гал унтраах удирдагч, штабын дарга зэрэг шаардлагатай албан тушаалтанд өгөх зөвлөмжүүд багтсан мэдээлэлийн программ бий болгох (программыг бий болгосноор Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагч гал түймрийн удирдлагыг бүрэн явуулах боломжтой болох нөхцөл бүрдэж байна.

5. Гал гарсан обьектын танилцуулга болон барилгын зураг, гарсан галыг унтраах арга тактик, Гал унтраах удирдагч, штабын дарга зэрэг шаардлагатай албан тушаалтанд өгөх зөвлөмжүүд багтсан мэдээлэлийг гар утас болон таблет ашиглан гал унтраах удирдагч шийдвэр гаргахад гарын авлага болгох андройд апплекейшн бий болгосноор гал унтраах штабыг мэдээ мэдээллээр бүрэн хангах нөхцөл бүрдэх юм.

Онцгой байдлын мэргэжлийн үйлчилгээг ард иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэхийн тулд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх,

эрсдлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, нийгмийн аюулгүй байдлыг хангахад шинжлэх ухааны ололт амжилт, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, олон нийт хамтын ажиллагааг идэвхижүүлэн, шинэ шатанд гаргана гэж үзэж байна.

***П.Батбаяр -****Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, онцгой байдлын дэд хурандаа*

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

***Хураангуй.*** *Онцгой байдлын албанаас аливаа болзошгүй аюулт үзэгдэл, ослын үеийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах зарим асуудлыг хөндөж тавихыг зорилоо.*

***Түлхүүр*** *үг. Аюулт үзэгдэл, осол, гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохицуулалт.*

Уур амьсгалын өөрчлөлт, дулаарал. хүмүүсийн зохисгүй зарим үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх аюулт үзэгдэл, ослын тоо. учрах хохиролын хэмжээ жилээс жилд манай улсад өсөн нэмэгдэж байгаа нь тоо баримтаас харагдах бөгөөд нэгэнт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын үед ард иргэдэд зарлан мэдээлэл хүргэх, эрэн хайх. аврах ажиллагаа явуулах. нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх арга хэмжээг зөв оновчтой, хурдан шуурхай зохион байгуулах нь Онцгой байдлын албаны шуурхай удирдлага, зохицуулалтаас ихээхэн шалтгаалах билээ.

Онцгой байдлын алба нь Гамшгаас хамгаалах тухай хуулиар үндсэн 4 чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан

1. гамшгаас урьдчилан сэргийлэх
2. гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах
3. гамшгийн хор уршгийг арилгах
4. хойшлуулшгүй сэргээн босгох

Дээрх үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахаар Монгол Улсын Их хурлаас ‘Гамшгаас хамаалах тухай" хуулийн шинэчилсэн найруулагыг 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлан, мөрдөгдөж байна.

Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж,